



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/25/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он	Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyam@audit.gov.mn Аудитын менежер Д.Энхдалай Утас: 261628 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор Л.Нямтөмөр Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn Аудитор М.Лхагвасүрэн Цахим хаяг: lkhagvasuren@audit.gov.mn Утас: 261740
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.3 Авлага	13
3.5.4 Урьдчилгаа	14
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	15
3.5.6 Бараа материал	15
3.5.7 Үндсэн хөрөнгө	16
3.5.8 Өр төлбөр	16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт	21
Залруулсан алдаа	21
Төлбөрийн акт	22
Албан шаардлага	22
Зөвлөмж	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	25
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1335

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 117,297.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Толилуулга ба Тодруулга", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,333,934,128.3	2,356,458,023.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,064,359,716.5	342,887,384.5
33	АВЛАГА	315,086,288.0	244,654,748.4
34	УРЬДЧИЛГАА	445,444,365.4	1,185,224,150.6
35	БАРАА МАТЕРИАЛ	480,917,933.8	552,879,924.7
36	НӨӨЦИЙН БАРАА	28,125,824.6	30,811,815.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,893,719,738.3	24,455,340,975.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	2,628,650,830.7	3,011,578,315.9
371	Урт хугацаат хадгаламж	7,350,144.8	-
373	Урт хугацаат зээл	2,621,300,685.8	3,011,578,315.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,265,068,907.7	21,443,762,659.3
391	Газар	-	230,538,398.6
392	Биет хөрөнгө	1,948,017,209.9	3,028,783,019.1
393	Биет бус хөрөнгө	11,220,518,785.4	13,693,273,991.4
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,096,532,912.3	4,491,167,250.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,227,653,866.6	26,811,798,999.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,465,872,118.1	5,168,689,925.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	785,306,828.4	1,906,013,456.4
411	Богино хугацаат үнэт цаас	-	212,469,775.7
412	Богино хугацаат зээлийн өглөг	103,443,612.3	416,678,007.0
413	Өглөг	576,523,872.8	828,873,429.7
414	Урьдчилж орсон орлого	105,339,343.2	447,992,243.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	680,565,289.7	3,262,676,468.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,761,781,748.5	21,643,109,073.9
51	Засгийн газрын хувь оролцоо	17,761,123,199.5	21,642,450,524.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	10,491,929.8	10,491,929.8
51101	Өмч: - төрийн /ТӨҮГ/	28,817,755.5	25,966,555.5
51102	Өмч: - хувийн /ТӨҮГ//	3,000.0	3,400.0
51103	Өмч: - хувьцаат	11,197,208,710.0	11,664,710,710.0
51105	Нэмж төлөгдсөн капитал	1,356,775.3	1,356,775.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	2,624,922,064.0	6,005,915,835.8
512	Хуримтлагдсан үр дүн	3,678,815,716.5	2,956,611,851.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,507,248.4	967,736,336.4
51600	Нөөцийн сан	-	9,657,130.6
52	Хяналтын бус хувь оролцоо	658,549.0	658,549.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,227,653,866.6	26,811,798,999.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөг/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,749,460,234.2	2,663,357,623.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,644,525.1	40,424,533.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,644,525.1	40,424,533.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,673,181,258.8	2,589,762,876.1
120	Нийтлэг татварын бус орлого	3,671,594,049.0	2,589,762,876.1
122	Тусламжийн орлого	1,587,209.8	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,634,450.2	33,170,213.2
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,180,975,831.9	2,140,255,689.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,180,975,831.9	2,140,151,067.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,879,524,922.0	1,987,310,547.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,208,923.0	5,595,131.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	484,769.1	730,533.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,209.0	187,992.0
2104	Хангамж, бараа материалын зардал	355,243.1	418,508.9
2105	Нормативт зардал	725.1	396.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	225,683.0	178,569.0
2107	Томилолт, зочны зардал	917,681.1	177,539.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,870,903,770.2	1,978,198,284.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,172,918.4	1,823,594.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,450,910.0	152,840,519.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,568,484,402.2	523,101,933.3
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	26,216,649.8	4,465,089.6
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,385,951.4	1,854,645.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,593,315,100.6	525,712,377.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,866,682,000.5	0.0	13,866,682,000.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,579,502,625.2	0.0	1,579,502,625.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,446,184,625.7	0.0	15,446,184,625.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	17,175,601.5	0.0	17,175,601.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-6,386,701.9	0.0	-6,386,701.9
Өмчид гарсан өөрчлөлт	895,396,321.3	0.0	895,396,321.3
Зарласан ногдол ашиг	-183,903,198.7	0.0	-183,903,198.7
Тайлант үеийн үр дүн	1,593,315,100.6	0.0	1,593,315,100.6
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,761,781,748.5	0.0	17,761,781,748.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-14,922,821.7	0.0	-14,922,821.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,746,858,926.8	0.0	17,746,858,926.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	757,718,034.7	0.0	757,718,034.7
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-3,117,962.4	0.0	-3,117,962.4
Өмчид гарсан өөрчлөлт	3,848,496,771.9	0.0	3,848,496,771.9
Зарласан ногдол ашиг	-1,235,677,036.8	0.0	-1,235,677,036.8
Тайлант үеийн үр дүн	525,712,377.4	0.0	525,712,377.4
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,643,109,073.9	0.0	21,643,109,073.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөг/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,801,365,110.0	4,206,769,060.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	42,644,525.1	40,437,147.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	42,644,525.1	40,437,147.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	42,644,525.1	40,437,147.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,725,088,276.2	4,133,039,691.5
120	Нийтлэг татварын бус орлого	5,723,501,066.4	4,133,039,691.5
122	Тусламжийн орлого	1,587,209.8	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,632,308.7	33,292,221.7
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,222,843,850.5	3,568,888,887.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,222,843,850.5	3,568,888,887.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,916,738,255.2	3,415,428,545.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,573,297.4	405,556,181.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,777,699.1	104,888,751.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,345,977.1	229,948,519.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,368,772,155.7	957,311,552.5
2105	Нормативт зардал	1,386.0	1,706.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	288,062.0	321,010.2
2107	Томилолт, зочны зардал	953,026.4	183,255.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,894,703,622.6	1,717,038,653.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	323,028.8	178,917.2
211	ХҮҮ	4,572,839.7	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	301,532,755.6	153,460,342.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,578,521,259.5	637,880,172.5
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	32,513,875.3	28,591,740.2
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	882,230,682.0	854,839,467.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	882,230,682.0	854,839,467.8
2200	Дотоод эх үүсвэр	882,230,682.0	854,839,467.8
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(849,716,806.7)	(826,247,727.6)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(290,434,284.0)	(533,104,776.9)
14	Бусад эх үүсвэр	475,322,796.1	595,022,952.4
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	765,757,080.1	1,128,127,729.4
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	438,370,168.8	(721,472,332.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	625,989,547.6	1,064,359,716.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,064,359,716.5	342,887,384.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,192,188,600.00	34,642,057,286.95	1,550,131,313.05	95.7
УРСГАЛ ЗАРДАЛ	11,914,323,300.00	10,685,746,603.95	1,228,576,696.05	89.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,981,741,700.00	8,666,975,992.51	314,765,707.49	96.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,141,427,900.00	5,077,371,910.50	64,055,989.50	98.8
Үндсэн цалин	3,264,052,600.00	2,813,219,480.37	450,833,119.63	86.2
Нэмэгдэл	1,209,880,400.00	1,413,372,926.51	(203,492,526.51)	116.8
Унаа хоолны хөнгөлөлт	318,166,800.00	482,091,408.71	(163,924,608.71)	151.5
Урамшуулал	349,328,100.00	368,688,094.91	(19,359,994.91)	105.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	694,092,600.00	674,816,311.16	19,276,288.84	97.2
Тэтгэврийн даатгал	488,435,600.00	469,159,311.16	19,276,288.84	96.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,537,200.00	129,356,639.96	15,180,560.04	89.5
Гэрэл, цахилгаан	24,105,600.00	25,643,832.54	(1,538,232.54)	106.4
Түлш, халаалт	72,006,400.00	77,851,506.36	(5,845,106.36)	108.1
Цэвэр, бохир ус	26,197,700.00	4,261,301.06	21,936,398.94	16.3
Байрны түрээс	22,227,500.00	21,600,000.00	627,500.00	97.2
Хангамж, бараа материалын зардал	263,153,400.00	253,959,572.92	9,193,827.08	96.5
Бичиг хэрэг	68,196,400.00	64,929,850.00	3,266,550.00	95.2
Тээвэр, шатахуун	77,118,900.00	73,127,944.00	3,990,956.00	94.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	58,541,900.00	58,141,870.92	400,029.08	99.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	634,300.00	625,900.00	8,400.00	98.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,661,900.00	57,134,008.00	1,527,892.00	97.4
Нормативт зардал	1,206,000.00	1,202,000.00	4,000.00	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,206,000.00	1,202,000.00	4,000.00	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	349,259,800.00	293,036,948.00	56,222,852.00	83.9
Багаж, техник, хэрэгсэл	66,600,100.00	46,569,718.00	20,030,382.00	69.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	232,700,500.00	197,836,910.00	34,863,590.00	85.0
Урсгал засвар	49,959,200.00	48,630,320.00	1,328,880.00	97.3
Томилолт, зочны зардал	144,661,700.00	133,920,073.80	10,741,626.20	92.6
Дотоод албан томилолт	144,661,700.00	133,920,073.80	10,741,626.20	92.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,044,430,100.00	1,923,090,357.17	121,339,742.83	94.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,721,305,900.00	1,616,195,589.50	105,110,310.50	93.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,772,000.00	2,120,000.00	652,000.00	76.5
Даатгалын үйлчилгээ	53,781,300.00	49,121,694.00	4,659,606.00	91.3
Тээврийн хэрэгслийн татвар	6,966,000.00	6,335,253.00	630,747.00	90.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,850,000.00	1,743,552.00	106,448.00	94.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,199,000.00	237,950,040.40	9,248,959.60	96.3
Газрын төлбөр	6,400,000.00	5,564,308.00	835,692.00	86.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,155,900.00	4,059,920.27	95,979.73	97.7
Бараа үйлчилгээний бусад зардал	198,973,000.00	180,222,179.00	18,750,821.00	90.6
Бараа үйлчилгээний бусад зардал	198,973,000.00	180,222,179.00	18,750,821.00	90.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,932,581,600.00	2,018,770,611.44	913,810,988.56	68.8
Бусад урсгал шилжүүлэг	2,932,581,600.00	2,018,770,611.44	913,810,988.56	68.8

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,000,000.00	21,420,823.00	1,579,177.00	93.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,628,250,000.00	1,780,140,508.67	848,109,491.33	67.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	267,821,600.00	203,801,679.77	64,019,920.23	76.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,510,000.00	13,407,600.00	102,400.00	99.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,277,865,300.00	23,956,310,683.00	321,554,617.00	98.7
Дотоод эх үүсвэрээр	24,277,865,300.00	23,956,310,683.00	321,554,617.00	98.7
Барилга байгууламж	1,969,766,700.00	1,649,189,721.00	320,576,979.00	83.7
Их засвар	105,000,000.00	104,622,371.00	377,629.00	99.6
Тоног төхөөрөмж	2,013,100,000.00	2,012,544,767.00	555,233.00	100.0
Бусад хөрөнгө	20,189,998,600.00	20,189,953,824.00	44,776.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,192,188,600.00	34,642,057,286.95	1,550,131,313.05	95.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,563,938,600.00	32,861,916,778.28	702,021,821.72	97.9
Улсын төсвөөс санхүүжих	33,563,938,600.00	32,861,916,778.28	702,021,821.72	97.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,628,250,000.00	1,780,140,508.67	848,109,491.33	67.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,628,250,000.00	1,780,140,508.67	848,109,491.33	67.7
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	263	263	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	263	263	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,296,460.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,296,460.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,296,460.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,129,382.72
210101	Үндсэн цалин	9,442,437.72
210105	Гэрээт ажлын хөлс	16,686,945.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,078,790.54
210201	Тэтгэврийн даатгал	3,638,900.54
210204	Ажилгүйдлийн даатгал	3,439,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,287.01
210401	Бичиг хэрэг	88,287.01
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,296,460.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,296,460.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,296,460.27

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, техник, аргачлал хяналтын зардлыг судалгаа тооцоонд үндэслэн бодитоор төлөвлөж, судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/871 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд оршино.¹

Дээрх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Түлш (эрчим хүчний нүүрснээс бусад)-ний хангамж, нөөцийн талаарх бодлого боловсруулах, газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрийн суурийг тавьж хөгжүүлэх, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрийг байгуулах;
- Байгалийн хий болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) талаарх судалгаа, хайгуул, олборлолтыг дэмжин хөгжүүлж, хийжүүлэх, шингэрүүлэх замаар гүн боловсруулалт хийх, ТЭЗҮ боловсруулах, боловсруулах үйлдвэр байгуулах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх;

¹ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоол “уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай.

- Уул уурхайн салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байгаль орчинд халгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/330 дугаар тушаалаар батлан санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, эрх зүйн акт болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2020 онд 4 чиглэлээр дотоод аудитыг гүйцэтгэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/57 тоот тушаалаар батлуулсан боловч дараах 2 аудитыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний 13 байгууллагын 2020 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитаар эхний 7 сарын байдлаар байршуулбал зохих 201 мэдээллээс 40 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илрүүлжээ.

Мөн геологийн судалгааны ажлын хөрөнгийн зарцуулалтад хийсэн дотоод аудитаар ЭБМЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, судалгааны ажлын үр дүнг шуурхай хэлэлцэх, үр дүнг тооцох журмыг шинэчлэх, геологийн судалгааны ажлын төлөвлөлтөд мэргэшсэн зөвлөхүүдийн саналыг тусгах зэрэг зөвлөмж өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг MNS 6817-4: 2020 стандартын дагуу тодорхойлохдоо суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,182,361.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43,647.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,142,110.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 42,842.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,064,359.7 сая, эцсийн үлдэгдэл 342,887.5 сая төгрөг болж, 721,472.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	139.1	121.4	(17.7)
Банканд байгаа бэлэн мөнгө	796,301.8	324,610.9	(471,690.9)
Замд яваа мөнгөн хөрөнгө	340.0	-	(340.0)
Хадгаламж	267,578.8	18,155.2	(249,423.6)
Дүн	1,064,359.7	342,887.5	(721,472.2)

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дүн 721,472.2 сая төгрөгөөр буурсан нь Ковид-19 халдварт цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагааны орлого буурсан, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бондын төлбөрт 383,000.0 сая төгрөг, “Таван толгой түлш” ХХК-ийн санхүүжилтэд 148,750.0 сая төгрөг, ТУЗ-ийн 2020 оны “Ногдол ашиг хуваарилах тухай” 09 дүгээр тогтоолын дагуу ногдол ашигт 179,830.2 сая төгрөгийг тус тус төлсөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Мөнгөн хөрөнгийн 342,887.5 сая төгрөг Тухайлбал: ТӨҮГ-ын /”Эрдэнэс-Тавантолгой” ХК 134,579.8 сая, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 106,035.8 сая, “Эрдэнэс силвер ресурс” ХХК 35,371.8 сая, “Монголросцветмет” ТӨҮГ 30,886.9 сая, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК 7,870.2 сая төгрөг/ үлдэгдэл байна.

Хадгаламжийн данс дахь 18,155.2 сая төгрөгийн үлдэгдэл нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Тээвэр хөгжлийн банк болон Кредит банкны дансанд байршуулсан хойшлогдсон хөрөнгө оруулалтын мөнгө байна.

Нэр бүхий банкнуудад байршсан харилцах дансны үлдэгдэл 126,808.2 сая төгрөг тооцоо саатан хязгаарлалтад өртсөн байна. /”Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-45,267.1 сая төгрөг, “Эрдэнэс-Тавантолгой” ХК 81,541.1 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар нийт 40.1 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Үүнд: “Эрдэнэс Монгол” ХХК 31.7 сая, УУХҮЯ-ны аппарат-8.4 сая/;
- Ажилтнуудад нэмэгдэл цалин, урамшуулал илүү тооцсон, сарын үндсэн цалингаас хэт их хэмжээтэй урьдчилгаа зэрэгт нийт 400.6 сая төгрөг олгосон. Үүнд: /”Эрдэнэс Монгол” ХХК 124.6 сая, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГ 16.7 сая, “Эрдэнэс Оюу толгой” ХХК 31.1 сая, Ашигт малтмал, газрын тосны газар 228.2 сая/;
- Ашигт малтмал, газрын тосны газар “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого”-ыг төсөвт тусгаж батлуулалгүй 971.9 сая төгрөгийг зарцуулсан.
- “Таван толгой төмөр зам” ХХК 1,174.6 сая төгрөгийн бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ хийсэн байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 315,086.3 сая, эцсийн үлдэгдэл 244,654.7 сая төгрөг болж, 70,431.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	17.3	16.9	(0.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	26.7	54.2	27.5
Татаас, санхүүжилтийн авлага	122.0	329.2	207.2
Дансны авлага /ТӨҮГ/	247,387.3	70,644.0	(176,743.3)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	3,768.6	106,970.0	103,201.4
Бусад авлага	63,764.4	66,640.4	2,876.0
Дүн	315,086.3	244,654.7	(70,431.6)

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын данс 70,431.6 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Байгууллага болон хувь хүнээс авах авлага "Монголросцветмет" ТӨҮГ 3,683.2 сая, "Эрдэнэс Монгол" ХХК 2,506.7 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 113,153.8, Ашигт малтмал, газрын тосны газар 164.7 сая, "Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК 105.3 сая, "Эрдэнэс силвер ресурс" ХХК 732.1 сая, "Геологийн судалгааны төв" ТӨҮГ 148.8 сая, "Геологийн төв лаборатори" ТӨҮГ 167.1 сая, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ 44.0 сая төгрөгөөр өссөн.
- "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 199,238.7 сая, "Багануур" ХК 4,107.2 сая, УУХҮЯ 12.3 сая, "Мон Атом" ХХК 4.5 сая, "Эрдэнэс метан" ХХК 1.1 сая, "Эрдэнэс ассет менежмент" ХХК 0.9 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдлийн 244,654.7 сая төгрөг нь /"Эрдэнэс Тавантолгой" ХК 26,351.5 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 135,488.7 сая, "Эрдэнэс Монгол" ХХК 14,365.2 сая, "Тавантолгой Төмөр зам" ХХК 38,396.7 сая, Ашигт малтмал, газрын тосны газар 9,248.7 сая, "Шивээ овоо" ТӨХК-ийн 2,634.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдлийг цаг тухайд нь барагдуулаагүйгээс 1998-2019 онуудад найдваргүй авлага их хэмжээгээр үүсэж, олон жилийн насжилттай 36,110.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 31,623.5 сая, "Эрдэнэс Тавантолгой" ХК 2,778.2 сая, "Эрдэнэс Монгол" ХХК 76.6 сая, "Эрдэнэс Алт Ресурс" ХХК 7.9 сая, "Багануур" ХК 803.2 сая, "Монголросцветмет" ТӨҮГ 440.0 сая, "Геологийн төв лаборатори" ТӨҮГ 380.9 сая төгрөг байна. Эдгээр авлага нь нийт авлагын 14.8 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 16,049.9 сая төгрөгийн авлага байна. Үүнд: /"Геологийн төв лаборатори" ТӨҮГ 878.9 сая, "Эрдэнэс Тавантолгой" ХК 1,509.6 сая, "Багануур" ХК 1,745.5, Ашигт малтмал, газрын тосны газар 8,334.1 сая, "Монголросцветмет" ТӨҮГ 57.1 сая/

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 445,444.3 сая, эцсийн үлдэгдэл 1,185,224.2 сая төгрөг болж, 739,779.9 сая төгрөгөөр өссөн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар	12,366.2	898,702.6	886,336.4
Урьдчилж гарсан зардал	381,448.0	229,384.6	(152,063.4)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	51,420.3	38,955.6	(12,464.7)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	11.1	18,153.3	18,142.2
Томилолтын урьдчилгаа	198.7	38.2	(160.5)
Дүн	445,444.3	1,185,224.2	739,779.9

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс 739,779.9 сая төгрөгөөр өссөн нь "Эрдэнэс монгол" ХХК Эрчим хүчний экспортын Шивээ энерги цогцолбор төсөлд 252.5 сая төгрөг, Монголросцветмет ТӨҮГ "Монголын далд уурхайн музейн, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн нэгжид 477.4 сая төгрөг олгосон зэрэг нь нөлөөлжээ.

Урьдчилгаа дансанд 1,185,224.2 сая төгрөг байна. Тухайлбал: "Эрдэнэс Тавантолгой" ХК 898,673.5 сая, "Тавантолгой төмөр зам" ХК 95,078.7 сая, "Эрдэнэс силвер ресурс" ХХК 18,153.3 сая, "Эрдэнэс Монгол" ХХК 2,174.4 сая, "Шивээ овоо" ТӨХК 5,880.1 сая, "Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК 4,963.0 сая, Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологи судалгааны ажлын санхүүжилтийн 71,894.2 сая, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ийн 2021 оны ААНОАТ-т урьдчилж төлсөн 73,066.8 сая нийт 1,185,224.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Геологийн судалгааны 2016-2019 онуудад хийгдсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, ажлын тайлан болон холбогдох материалыг хүлээн авч, урьдчилгаа төлбөрийн дансны үлдэгдлийг бууруулж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүйгээс үүссэн 10,025.5 сая төгрөгийн хуримтлагдсан урьдчилгаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 2,628,650.8 сая, эцсийн үлдэгдэл 3,011,578.3 сая төгрөг болж, 382,927.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат хадгаламж	7,350.1	-	(7,350.1)
Урт хугацаат зээл	2,621,300.7	3,011,578.3	390,277.6
Дүн	2,628,650.8	3,011,578.3	382,927.5

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт 382,927.5 сая төгрөгөөр өссөн нь “Оюу Толгой” ХХК-ийн гаргасан хувьцааны “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34%-д ногдох 385,643.5 сая төгрөг өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас охин болон хараат компаниудад шилжүүлсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл болон банкны зээлийн үлдэгдэл 321,931.3 сая төгрөг байна. Үүнд: /“Эрдэнэс Тавантолгой” ХК 309,341.3 сая, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 7,383.9 сая, “Эрдэнэс метан” ХХК 139.8 сая, “Эрдэнэс Монгол” ХХК 3,394.6 сая, “Мон Атом” ХХК 1,670.7 сая, “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК 1.0 сая/ бүртгэлтэй байна. Мөн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалтын дансанд “Оюу Толгой” ХХК-ийн төрийн өмчид ногдох 34 хувийн хувьцааны ногдол ашгийн 2,689,647.0 сая төгрөгийг бүртгэжээ.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 480,917.9 сая, эцсийн үлдэгдэл 552,879.9 сая төгрөг болж, 71,962.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	252,043.7	278,067.3	26,023.6
Дуусаагүй үйлдвэрлэл	4,443.5	5,842.9	1,399.4
Бэлэн бүтээгдэхүүн	124,171.0	168,109.2	43,938.2
Хангамжийн материал	100,259.7	100,860.5	600.8
Дүн	480,917.9	552,879.9	71,962.0

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 71,962.0 сая төгрөгөөр өссөн, тухайлбал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний үлдэгдэл 23,651.7 сая төгрөгөөр өссөн, “Эрдэнэс силвер ресурс” ХХК 1,707.6 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 4,589.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, “Багануур” ХК цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж цахилгаан станцуудад хоногт нийлүүлэх нүүрсний хэмжээ 8-9 вагоноор нэмэгдсэнтэй холбоотойгоор техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс 31,224.8 сая төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн зэрэг нь тайлант оны санхүүгийн тайлангаарх бараа материал өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- “Багануур” ХК Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнээс давсан 10,389.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн.

- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй 484.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үр ашиггүй зардал гаргасан байна. Тухайлбал: “Монголросцветмет” ТӨҮГ 469.3 сая төгрөг, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ 15.3 сая төгрөг/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 14,265,068.9 сая, эцсийн үлдэгдэл 21,443,762.7 сая төгрөг болж, 7,178,693.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	230,538.4	230,538.4
Биет хөрөнгө	1,948,017.2	3,028,783.0	1,080,765.8
Биет бус хөрөнгө	11,220,518.8	13,693,274.0	2,472,755.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,096,532.9	4,491,167.3	3,394,634.4
Дүн	14,265,068.9	21,443,762.7	7,178,693.8

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Харьяа төсөвт байгууллага, ТӨҮГ-ууд нь ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрийн дагуу 268,345.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 916,309.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, 31,410.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансанд 486,015.5 сая төгрөгийн дараах байгууллагуудын хөрөнгө байна.Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтын 5,033.9 сая;
- “Эрдэнэс таван толгой” ХК 9,302.9 сая;
- “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК 24,489.2 сая;
- “Эрдэнэс алт ресурс” ХХК 1,238.4 сая;
- “Монголросцветмет” ТӨҮГ 1,439.3 сая;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 443,775.9 сая;
- “Эрдэнэс силвер ресурс” ХХК 735.9 сая төгрөгийн хөрөнгө үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 11,429.8 сая төгрөгийн 14 автомашин улсын дугааргүй, эзэмшигч нь тодорхойгүй;
- “Эрдэнэс Монгол” ХХК 2020 онд өөрийн хөрөнгөөр 141.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ ТӨБЗГ-аас шийдвэр гаргуулаагүй;
- “Таван толгой төмөр зам” ХК ТӨБЗГ-ын тогтоолоор хүлээн авч данс бүртгэлд тусгасан 107.8 сая төгрөгийн үнэтэй автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ “Монголын Төмөр зам” ТӨХК-ийн нэр дээр байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,465,872.1 сая, эцсийн үлдэгдэл 5,168,689.9 сая төгрөг болж, 3,702,817.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	785,306.8	1,906,013.4	1,120,706.6
Богино хугацаат үнэт цаас	-	212,469.8	212,469.8
Богино хугацаат зээлийн өглөг	103,443.6	416,678.0	313,234.4
Өглөг	576,523.9	828,873.4	252,349.5
Урьдчилж орсон орлого	105,339.3	447,992.2	342,652.9
Урт хугацаат өр төлбөр дүн	680,565.3	3,262,676.5	2,582,111.2
Урт хугацаат үнэт цаас	-	736,537.0	736,537.0

Урт хугацаат зээл	680,565.3	2,526,139.5	1,845,574.2
Нийт дүн	1,465,872.1	5,168,689.9	3,702,817.8

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр 3,702,817.8 сая төгрөгөөр өссөн нь Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,906,013.4 сая төгрөг болж, 1,120,706.6 сая төгрөгөөр, Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 3,262,676.5 болж, 2,582,111.2 сая төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр өссөн шалтгааныг дурдвал:

“Эрдэнэс силвер ресурс” ХХК “Эрдэнэс-2”, “Эрдэнэс-3” бондын 2021 онд төлөх 212,469.8 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөрөөс богино хугацаат өр төлбөрт шилжүүлэн бүртгэжээ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн өр төлбөр дансны үлдэгдэл 963,034.5 сая төгрөг болж 929,861.0 сая төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банк, Хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээл, “Эрдэнэс таван толгой” ХК-д төлөх “Эрдэнэс-1” бондын өглөг зэрэг байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өр төлбөр дансны үлдэгдэл 2,040,853.7 сая төгрөг болж 1,685,626.8 сая төгрөгөөр өссөн нь ТУЗ-ийн 2020 оны “Ногдол ашиг хуваарилах тухай” 09 дүгээр тогтоолын дагуу төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашгийн өр 880,188.7 сая төгрөг, нүүрсний борлуулалтын урьдчилж орсон орлого 316,143.3 сая төгрөг, ХААН болон Голомт банкуудад төлөх зээл болон зээлийн хүүгийн өр 330,150.6 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-д бондын санхүүжилтийн өглөг 933,607.8 сая төгрөгийг өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өглөгийн 216,606.0 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. Үүнд: /“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 4,036.9 сая, “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн “Эрдэнэс-2”, “Эрдэнэс-3” бондын өглөг 212,469.8 сая/

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 17,761,123.3 сая, эцсийн үлдэгдэл 21,642,450.5 сая төгрөг болж, 3,881,327.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо

	/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,491.9	10,491.9	-	
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	28,817.8	25,966.6	(2,851.2)	0.1
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	3.0	3.4	0.4	
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,197,208.7	11,664,710.7	467,502.0	53.9
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	1,356.8	1,356.8	-	
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,624,922.1	6,005,915.8	3,380,993.7	27.8
Хуримтлагдсан үр дүн	3,678,815.7	2,956,611.8	(722,203.9)	13.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,507.3	967,736.3	748,229.0	4.5
Нөөцийн сан		9,657.2	9,657.2	
Дүн	17,761,123.3	21,642,450.5	3,881,327.2	100.0

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 6,005,915.8 сая төгрөг болж 3,380,993.7 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ Монгол Улсын хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу газар эзэмших, ашиглах эрхийг шинээр үнэлж 2,473,982.8 сая төгрөг, “Оюу Толгой” ХХК-ийн гаргасан

хувьцааны “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 34%-д ногдох хувьцаа 385,643.5 сая төгрөгөөр өсөж 2,689,647.0 сая, “Тавантолгой төмөр зам” ХХК хувьцаа эзэмшигчдээс нэмж хөрөнгө оруулснаар 472,939.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 781,812.0 сая төгрөгийг эздийн өмчийн бусад хэсэгт тайлагнасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг нэгтгэсэн нь өмч 2,851.2 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 967,736.3 сая төгрөг болж 748,229.0 сая төгрөгөөр өссөн нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж 467,809.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 828,350.2 сая, “Багануур” ХК 63,940.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 60,685.4 сая, “Монголросцветмет” ТӨҮГ 40,392.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 52,657.7 сая төгрөгөөр дахин үнэлүүлэн бүртгэсэн нь нөлөөлжээ.

Хувьцааны үлдэгдэл 11,664,710.7 сая төгрөг болж, 467,502.0 сая төгрөгөөр өссөн нь “Таван толгой төмөр зам” ТӨҮГ Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 5 дугаар тогтоолоор 187,000,000 ширхэг 467,500.0 сая төгрөгийн энгийн хувьцаа эргэлтэд оруулж, Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан 34 хувиар хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлж бүртгэсэнтэй холбоотой байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны дансны үлдэгдэл нь 12.0 сая ширхэг, 933 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 11,196,000.0 сая төгрөгийн хувьцаа байна.

Хуримтлагдсан үр дүн 2,956,611.9 сая төгрөг болж, 722,203.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд 5 төрлийн эх үүсвэрээс 159,200.0 сая төгрөгийн орлого олж улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150,412.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 94.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №9. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	30,000.0	32,715.4	2,715.4	109.1
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордн нөхөн төлбөр	6,600.0	7,721.8	1,121.8	117.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого /сонгон шалгаруулалтын орлого/	9,000.0	4,286.6	(4,713.4)	47.6
Бусад орлого	3,600.0	2,931.7	(668.3)	81.4
Газрын тосны орлого	110,000.0	102,757.3	(7,242.7)	93.4
Нийт дүн	159,200.0	150,412.9	(8,787.1)	

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 8,778.1 сая төгрөгөөр тасарсан нь “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал, Газрын тос, ашигт малтмалын экспорт буурсан нь нөлөөлжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 124,667.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Дээрх төсвийн төслийг Улсын нөөц бүрдүүлэлт, хадгалалтын зардлаас 51,883.5 сая, барилга байгууламжийн зардлаас 21,188.2 сая, хайгуул судалгааны зардлаас 7,009.6 сая, машин, тавилга, тоног төхөөрөмж 4,809.9 сая төгрөг зэрэг нийт 88,475.6 сая төгрөгөөр бууруулж 36,192.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 16 хөтөлбөрт зориулан нийт 36,192.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 11,914.3 сая төгрөгийг урсгал зардалд, 24,277.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 33,563.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,628.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвөөс гүйцэтгэлээр 32,861.9 сая төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс шилжүүлж, 702.0 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,780.1 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 848.2 сая төгрөгөөр тасарсан нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуух төвлөрүүлэх сургалтын урамшууллын орлого тасарсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 308.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 4,087.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 3,766.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, барьцаа данс болон захиалагчийн хяналтын дансанд 321.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн багцад 2020 онд Төсвийн тухай хуулиар батлагдсан 36,192.2 сая төгрөгийн төсвийн 95.7 хувь буюу 34,642.1 сая төгрөгийг зарцуулжээ. Төсвийн гол хэмнэлт орон тоо дутуу болон зарим ажлыг хавсран гүйцэтгэснээс цалингийн зардал 64.1 сая төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ашигт малтмал, газрын тосны газар БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэнгийн буцалтгүй тусламжаар “Монгол орны зүүн болон урд хэсэг 1:50000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх-Кигам” төслийн ажилд нийт 33,296.5 сая төгрөгийн нэмэлт төсвийн санхүүжилт авсан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлд 33,208.2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 88.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Шивээ овоо” ТӨХК-ийн үүсгэн байгуулсан охин компани “Шивээ сервис” ХХК нь санхүүгийн тайлангаа толгой компанийн санхүүгийн тайланд нэгтгэж тайлагнаагүй.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь эрх хэрэгжүүлэгчээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлж, “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани байсныг хүчингүй болгосон боловч ҮЦТХТ-ийн бүртгэлд 9,125,403.5 сая төгрөгийн хувьцаа “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй хэвээр байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь “Медипас нийгэмлэг”-тэй 2015 оны 8 сарын 20-ны өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үндэслэн 64,871.5 сая төгрөгийн хөрөнгийг “Медипас” ХХК-д шилжүүлэн 2018-2036 онуудад 18 жилийн хугацаанд хуваарийн дагуу сар бүр тогтмол дүнгээр эргэн төлөх үүрэг хүлээж ерөнхий болон дэд гэрээнүүд байгуулжээ. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 сарын 22-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн 1.3-т: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас “Медипас” ХХК-д шилжүүлж, авлагаар бүртгэсэн хөрөнгийн асуудлаар холбогдох материалыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар Сангийн сайдад, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захиралд даалгасан. “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Медипас” ХХК-тай байгуулсан ерөнхий болон дэд гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэж “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь холбогдох хуулийн дагуу цуцлуулахаар хууль хяналтын байгууллагад гомдол гаргасан боловч одоогоор шийдэгдээгүй байна. Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс, Нийслэлийн Прокурорын газрын ерөнхий прокурор, Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаад байгаа боловч одоогоор шийдэгдээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд салбарын төрийн өмчит хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж байгаа боловч төсвийн ерөнхийлөн захирагч нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхэд чиглэл өгөх, гэрээ байгуулах, дүгнэх, санхүүгийн үүрэгтэй холбоотой асуудлаар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байна.

УУХҮС-ын 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 чиглэлийн 16 ажил төлөвлөснөөс 89.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.9. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 179 мэдээллээс 176 мэдээллийг хугацаанд нь, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн бүтэн жилийн тайлан, 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 4 албан шаардлага, 9 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийн мөнгөн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	4	17,016.1	4	11,945.2	85.0
Зөвлөмж	9	838,274.1	9	782,124.8	93.3
Нийт дүн/ дундаж хувь	13	855,290.2	13	794,070.0	89.2

4 албан шаардлагаас 2 нь бүрэн хэрэгжиж, “Геологи судалгааны 11 төслийн гэрээг дүгнэж тайланг хамгаалуулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулан ажиллах” зөвлөмжөөр гэрээ дүгнээгүй асуудлаас 7 төслийн гэрээг дүгнэж, 4 төслийн гэрээ нь шийдвэрлэх шатандаа, 2014-2019 онуудад гүйцэтгэсэн геологи судалгааны ажлын биелэлтийг хүлээн авч, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх ажлын явц 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт 9 зөвлөмж өгснөөс 6 нь бүрэн хэрэгжиж, 3 зөвлөмжийн хэрэгжилт 80.0-90.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тухайлбал:

- “Харьяа ТӨҮГ-ууд олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж, баталгаажуулаагүй нийт 249,253.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлэх, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, шинээр авлага үүсгэхгүй, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах” зөвлөмжийн тооцоо нийлээгүй авлагыг 14,253.6 сая болгож бууруулсан, хуримтлагдсан авлага барагдуулах ажил 80.0 хувийн гүйцэтгэлтэй;
- “Харьяа ТӨҮГ-ууд нь нийт 134,311.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулж байх, барагдуулах арга хэмжээ авч ажиллах” зөвлөмжийн тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөгийг 23,031.9 сая төгрөг болгон бууруулж, барагдуулах ажил хэрэгжих шатандаа буюу 80.0 хувийн гүйцэтгэлтэй;
- “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг шинэчлэн батлах тухай журмын 3.14-дахь заалтыг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандарттай нийцүүлэн шинэчлэх.” зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувийн гүйцэтгэлтэй буюу журмын төслийг боловсруулж, салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, судлаач, эрдэмтэд, геологичдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, ирүүлсэн саналыг тусган, холбогдох өөрчлөлтүүдийг хийж УУХҮС-д танилцуулсан байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой төмөр зам” ХХК-уудын хооронд байгуулсан нүүрсний гэрээнд зааснаар тухайн оны хөрөнгө оруулалтыг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор хувьцаанд хөрвүүлэхээр заасан боловч ТУЗ-ийн шийдвэр гаргаагүй, гурван талын актаар баталгаажаагүй асуудлыг дараагийн аудитаар анхаарч горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 25 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс аудитад 23 байгууллага хамрагдаж, 18 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-д “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 408,515.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 308,184.2 сая төгрөгийн 35 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 100,337.6 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 759.1 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 72,003.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 52 албан шаардлага хүргүүлж, 27,574.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 73 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 17,288.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 329.2 сая төгрөгийн алдааг залруулж, 41.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 16,482.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 435.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Санхүүгийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд Ашигт малтмал, газрын тосны газрын нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 329.2 сая төгрөгийг нэгтгэсэн тайланд устгал хийснийг татаас санхүүжилтийн авлагаар тайлагнан залруулга хийлгүүлэв.

Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Геологийн байгууллагын 2012-2014 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын барьцаа төлбөрийн үлдэгдлээс 41.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, барьцаа дансны өглөгийн дансны зарцуулалт тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож, төсөвт төвлөрүүлэх.

Албан шаардлага

1. Геологийн байгууллагын 2011-2014 онуудад хийгдсэн судалгааны ажлын 46 хувь буюу 6,457.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн гэрээг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2015 оны 108 тоот тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 3.22-д "төсөл гүйцэтгэгч нь ...геологи судалгааны ажлын тайланг хугацаандаа ЭБМЗ, Геологийн мэдээллийн төв архивд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсоох, төлбөр торгуулийг барьцаа хөрөнгөнөөс барагдуулна", журмын 5.1-д "Төсөл гүйцэтгэгч нь геологи судалгааны ажлын үр дүнгийн тайланд шүүмж хийлгэн, ... ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна" гэсэн заалттай нийцэхгүй, Санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Геологийн байгууллагын судалгааны 2016-2019 онуудад хийгдсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг хүлээн авч, урьдчилгаа төлбөрийн дансны үлдэгдлийг бууруулж, тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй 10,025.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн хуримтлагдсан үлдэгдэлтэй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд.

1. Үндэсний геологийн алба нь Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 46 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5.5 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Үндэсний геологийн алба нь өглөгийн 0.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нараас техник хяналтын зардалд 298.8 сая төгрөг төвлөрүүлснээс 30 хувь буюу 89.5 сая төгрөгийг зарцуулсан нь техник, аргачлал хяналтын зардлыг судалгаа тооцоонд үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, судалгааны ажлын гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна. Техник, аргачлал хяналтын зардлын дансанд 435.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Уул уурхайн сайдын 2015 оны "Журам шинэчлэн батлах тухай" 108 дугаар тушаалын 3.14-т "Геологийн судалгааны ажлын хэрэгжилтийн явцад ... зэрэгт зориулан зарцуулах аргачлал, хяналтын зардлыг төсөл тус бүрийн өөрийн хүчээр гүйцэтгэх ажлын нийт дүнгийн 2.0 хүртэл хувьтай тэнцэх хөрөнгийг төсөл гүйцэтгэгчээс төрийн захиргааны төв байгууллагын геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлын дансанд төвлөрүүлэн зарцуулна" гэж заасантай тус тус нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Техник, аргачлал хяналтын зардлыг судалгаа тооцоонд үндэслэн бодитоор төлөвлөж, судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;

2. Харьяа байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 408,515.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 308,184.2 сая төгрөгийн 35 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 100,337.6 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 759.1 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 72,003.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 52 албан шаардлага хүргүүлж, 27,574.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 73 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 27 дугаар зүйлийн 27.1.1-д "төсвийн зарчмыг мөрдлөг болгох" 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэж заасантай нийцээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлүүдэд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг биелүүлж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/										
Д/Д	Харьяа байгууллагууд	Аудитад хамрагдалт			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Түүвэрт хамрагдсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	-	1	-	1	41.3	2	16,482.5	2	435.7
	ДҮН	-	1	-	1	41.3	2	16,482.5	2	435.7
Төрийн өмчит үйлдвэрийн газар										
1	"Геологийн судалгааны төв" ТӨҮГ	1	-	-	-	-	-	-	3	40.0
2	"Эрдэнэс Алт ресурс" ХХК	1	-	-	1	1.1	1	-	3	10.2
3	"Эрдэнэс Монгол" ХХК	1	-	-	2	37.0	6	310.0	9	195.9
4	"Эрдэнэс ассет менежмент" ХХК	1	-	-	-	-	1	-	1	-
5	"Шивээ овоо" ХК	1	-	-	2	7.6	3	8,613.8	3	15.2
6	"Багануур" ХК	1	-	-	-	-	1	1,745.5	5	401.1
7	"Геологийн төв лаборатори" ТӨҮГ	1	-	-	-	-	2	380.9	7	22.6
8	"Монголросцветмет" ХХК	1	-	-	4	682.0	6	804.5	2	-
9	"Эрдэнэс метан" ХХК	1	-	-	-	-	1	148.4	4	310.9
10	"Мон-Атом" ТӨХХК	1	-	-	1	1.5	-	-	3	243.6
11	"Монголын газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК	1	-	-	1	4.5	1	79.9	3	656.9
12	"Эрчис ойл" ХХК	1	-	-	-	-	1	-	1	99.3
13	"Эрдэнэс силвер ресурс" ХХК	1	-	-	-	-	2	953.4	2	1,118.4
14	"Эрдэнэс оюу толгой" ХХК	1	-	-	-	-	2	31.1	3	0.1
15	"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨААТҮГ	1	-	-	-	-	2	16.7	1	9.6
16	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	1	-	-	-	10	56,709.5	11	21,466.6
17	"Эрдэнэс таван толгой" ХК	1	-	-	-	-	2	358.7	5	2,954.0
18	"Таван толгой төмөр зам" ХХК	1	-	-	-	-	3	136.9	3	20.0
	ДҮН	17	1	-	11	733.7	44	70,289.3	69	27,564.4
Төсвийн шууд захирагч										
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-	1	-	1	2.0	2	468.3	3	10.5
2	Ашигт малтмал, газрын тосны газар	1	-	-	2	23.4	4	1,239.8	1	-
3	Үндэсний геологийн алба	-	-	1	-	-	2	6.2	-	-
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалт	-	-	1	-	-	-	-	-	-
5	Геологийн байгууллага	-	-	1	-	-	-	-	-	-
	ДҮН	1	1	3	3	25.4	8	1,714.3	4	10.5
	НИЙТ ДҮН	18	3	3	15	800.4	54	88,486.1	75	28,010.7

Хавсралт1

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын нэгтгэл

Харьяа байгууллага	д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
“Эрдэнэс Алт ресурс” ХХК	1	Тус байгууллага нь Ланд 200 маркын 52-70 УБҮ улсын дугаартай 1 машинтай байна. “Аюуд пропорти” ХХК-тай хийсэн түрээсийн гэрээгээр 2 машины зогсоол түрээсэлж түрээсийн төлбөрт 1.1 сая төгрөг илүү төлсөн байна.	1.1	Төлбөрийн акт	Захирал, Нягтлан бодогч	Б.Ачитсайхан, Б.Батсүх
	2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлээгүй, нийт 105 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	-	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	Б.Ачитсайхан, Б.Батсүх
“Эрдэнэс Монгол” ХХК	3	ТУЗ-өөс тогтоол гарган, төсвийг батлан, гүйцэтгэх захирлыг 2019 оны 9 дүгээр сард Оксфордын их сургуулиас зохион байгуулсан сургалт семинарт оролцуулахаар сургалтын төлбөрт 13.2 сая төг, зочид буудлын төлбөрт 3.0 сая төгрөг ИБУИНВУ руу шилжүүлсэн боловч сургалтад яваагүй байна. Иймээс мөнгөө буцаан авах хүсэлт явуулсан боловч буцаагаагүй байна /дараа жил ирж суралцах боломжтой гэсэн/. Гэтэл 3.0 сая төгрөгийг 2019 онд, 13.2 сая төгрөгийг 2020 оны 7 дугаар сарын 30-нд авлагыг хааж, зардалд бичсэн	16.2	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	4	Нэр бүхий 7 ажилтны цалин, ээлжийн амралтыг давхардуулан, 20.8 сая төгрөгийг олгосон байна	20.8	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	5	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирлын 2020 оны 7 дугаар сарын 9-ний А/77 тушаалаар бүх ажилтнуудад нэг удаагийн тэтгэмжийг хавтгайруулан олгосон /1 хүнийг үндсэн цалингийн 40хувиар/.	81.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	6	Захирлууд болон ТУЗ-ын дарга, гишүүдийг Хаан даатгалын “Удирдлагын хариуцлагын даатгал”-д	91.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий	

		2019 оны 11 дүгээр сарын 2-ноос 1 жилийн хугацаатай 68.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2019 онд 50 хувийг, 2020 онд үлдэгдлийг шилжүүлсэн. Мөн нийт ажилтнуудыг Хаан даатгал"-д 2020 оны 11дүгээр сарын 20-ноос 1 жилийн хугацаатай хамруулж 56.7 сая төгрөгийн гэрээ байгуулж, үргүй зардал гаргасан			нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	7	Нэр бүхий 2 удирдах ажилтанд 78.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосноос 2020 оны эцэст барагдаагүй 59.5 сая төгрөгийн үлдэгдэл байна.	59.5	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	8	Нэр бүхий 13 ажилтанд үндэслэлгүйгээр нийт 46.6 сая төгрөгийн нэмэгдэл /ямар нэмэгдэл нь тодорхойгүй/ цалин олгосон	46.6	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	9	Шатахууны тооцооллыг анхан шатны баримттай тулгахад 31.7 сая төгрөгийн тооцоо бодсон анхан шатны баримтгүй	31.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
	10	Шилэнд дансны мэдээлэл оруулах цахим сайтад хугацаа хоцроож, мэдээлэл байршуулсан байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Хаянхярваа, Т.Намжилмаа
"Эрдэнэс ассет менежмент" ХХК	11	Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 174 мэдээллээс 123 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Болормаа Г.Ганцэцэг
	12	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс илүү олгосон	2.2	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхтүвшин Н.Энхжаргал
	13	Тайлант онд мөрдөх боломжгүй, алдаатай хэвлэгдсэн НБББББ-ийн үлдэгдэл төлбөр шилжүүлсэн	5.4	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхтүвшин Н.Энхжаргал
	14	Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй	50.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхтүвшин Н.Энхжаргал
	15	Тайлант хугацаанд шилэн дансанд байршуулбал зохих 138 мэдээллээс 55 буюу 8,563.7 сая төгрөгийн	8,563.7	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий	Ц.Энхтүвшин Н.Энхжаргал

“Шивээ овоо” ХК		мэдээлэл хугацаа хоцроосон байна			нягтлан бодогч	
	16	Өмнөх аудитын зөвлөмж “НББОУС 19 Ажилтны тэтгэмж стандартын дагуу тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө, шимтгэлийн тооцооллыг актуар төсөөллөөр тооцоолуулж байхаар заасан тул энэ стандартын дагуу мэргэжлийн актуарчин оролцуулан тооцож байх”-ийг хангаж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхтүвшин Н.Энхжаргал
“Багануур” ХК	17	Авлагыг 1,745.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1,745.5	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Э.Номинчулуун П.Эрдэнээ
“Геологийн төв лаборатори” ТӨҮГ	18	2004-2010 онуудад үүссэн эзэн харилцагч нь тодорхой бус нийт 311 харилцагчийн 380.9 сая төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, найдваргүй авлагын нөөц сан байгуулах тухай 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	380.9	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Оюунбаатар М.Хоролсүрэн
	19	Геологийн төв лаборатори ТӨҮГ нь 2020 онд нийт 24 мэдээллийг Шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан	-	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ө.Оюунбаатар М.Хоролсүрэн
“Монгол Росцвет-мет” ТӨҮГ	20	Нийгэм соёлыг хөгжүүлэх сангаас зориулалт бусаар 92.3 сая төгрөгийг хавтгайруулан олгосон	92.3	Төлбөрийн акт	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
	21	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын 60 жилийн ойн ном хэвлэх зардалд 4.0 сая, урилга дугтуй хэвлэлийн зардалд 3.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан	7.5	Төлбөрийн акт	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
	22	Цахим төлбөрийн и баримтыг хянахад 1.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1.7	Төлбөрийн акт	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
	23	Захирлын тушаалаар нийт ажиллагсдад урамшуулал, удаан жилийн нэмэгдлийг давхардуулан 580.5 сая төгрөгийг олгосон.	580.5	Төлбөрийн акт	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
	24	Байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах нийт 1891 мэдээллээс 31 мэдээллийг байршуулаагүй	-	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат

25	Үйлдвэрийн газрын Захирлын 2019 оны А/485 тоот “Захиргаа, харьяа үйлдвэрийн ажиллагсдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгох тухай” тушаалаар 23 хүнд 114.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийг Нийгэм соёлыг хөгжүүлэх сангаас олгосон	114.8	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
26	Үйлдвэрийн газрын Захирлын №А/130 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайлангийн үр дүнгээр Захиргаа, “Бор-Өндөр” УБҮ, “Шижир алт” АҮ-ийн Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Төлөвлөлт, эдийн засаг шинжилгээний хэлтсийн нийт ажилчдад 163.3 сая төгрөгийн урамшууллыг Материаллаг урамшууллын сангаас олгож, үйл ажиллагааны бус зардалд тайлагнасан байна. Мөн уг урамшууллын дүнгээс НДШ суутгаагүй, НДШ төлөлтийн тайлангаар тайлагнаагүй	163.3	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
27	Захирлын 2020 оны 12 сарын 28-ны өдрийн А/570 тоот тушаалаар 434.4 сая төгрөгийн хадгалалтын явцад муудсан, ашиглах боломжгүй эргэлтийн хөрөнгийг данснаас хассан, дотоод хяналтын шалгалтын мөрөөр зохион байгуулсан төлөвлөгөөт хяналт шалгалтаар бараа материалтай холбоотой 34.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн, ашиглалтын чанар байдлыг тодорхойлоогүй, шаардлагагүй илүүдэл нөөц хөрөнгө бэлтгэсэн	469.3	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
28	Тайлант онд авлага болон өглөгийн нийт 57.1 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.	57.1	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
29	Тайлант оны Захиргаа, Бор-Өндөр, Шижир-Алт АҮ-ийн цалингийн дэлгэрэнгүй бүртгэл, цалинтай холбогдох тушаал, цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	-	Албан шаардлага	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б.Мөнхбат, Д.Баярбат
30	Шилэн дансанд 582.2 сая төгрөгийн 170 гүйлгээг оруулахаас 433.8 сая	148.4	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, ерөнхий	Д.Амар, Т.Цогбадрах

“Эрдэнэс метан” ХХК		төгрөгийн 168 гүйлгээг оруулж 148.4 сая төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй.			нягтлан бодогч	
“Мон Атом” ХХК	31	Хүлээн авалт, уулзалтын зардлыг тушаал шийдвэргүй гаргасан	1.5	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Далайжаргал Д.Батзаяа
“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”	32	Тушаал шийдвэргүй уулзалт, цайллагын үйл ажиллагаанд мөнгө зарцуулсан	4.5	Төлбөрийн акт	Гүйцэтгэх захирал, СЭЗГ-ын дарга	М.Алтанцэцэг, Б.Чинтуяа
	33	Бусдаас түрээсэлдэг байр талбайн түрээсийн төлбөрийг дээд газрын шийдвэрээс илүү үнээр түрээсэлсэн.	79.9	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, СЭЗГ-ын дарга	М.Алтанцэцэг, Б.Чинтуяа
“Эрчис ойл” ХХК	34	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 115 мэдээллээс 64 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	-	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ахлах нягтлан бодогч	З.Ширзана, Д.Мядагбадам
“Эрдэнэс силвер ресурс” ХХК	35	Санхүүгийн тайлан, тодруулга дахь авлага, өглөгийн дүнг дэлгэрэнгүй журналаас харилцагч бүрээр задалж, тооцооны үлдэгдлийн баталгаатай тулган шалгахад 4 харилцагчийн 83.1 сая төгрөгийн үлдэгдэл зөрүүтэй тооцоо нийлсэн, 16 харилцагчийн 17.6 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулж тооцоо нийлээгүй байна.	100.6	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Санхүүгийн албаны дарга	Т.Мөнхбаяр Б.Ичинхорлоо
	36	Шилэн дансны мэдээллийг шалгахад нийт 167 мэдээлэл оруулахаас 155 мэдээллийг хугацаа хоцроосон ба цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 510.5 сая төгрөгийн 16 гүйлгээ, зарлагын 342.3 сая төгрөгийн 35 гүйлгээг мэдээлээгүй байна.	852.8	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Санхүүгийн албаны дарга	Т.Мөнхбаяр Б.Ичинхорлоо
“Эрдэнэс оюу толгой” ХХК	37	Тайлант онд байгууллагын нэр бүхий 12 ажилтанд 31.1 сая төгрөгийн шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон байна.	31.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Түмэнцогт Г.Мөнхтөр
	38	Шилэн дансны нэгдсэн цахим системд 19 мэдээллийг хоцроож байршуулсан байна	-	Албан шаардлага		
	39	Тайлант онд байгууллагын нэр бүхий 31 ажилтанд 16.7 сая төгрөгийн шагналыг	16.7	Албан шаардлага	Захирал, Ерөнхий	Г.Гансүх, Б.Дэлгэрдалай

“Шингэн түлш ачих байгууламж”		хавтгайруулан олгосон байна			нягтлан бодогч	
	40	Шилэн дансны нэгдсэн цахим системд 13 мэдээллийг хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага		
“Эрдэнэт Үйлдвэр”	41	Нэр бүхий банкны харилцах дансны үлдэгдэл төлбөрийн гүйлгээ хийгдээгүй, тооцоо саатан, хязгаарлалтад өртсөн	45,267.1	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	42	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-96 тоот тушаалаар албадан татан буулгасан Капитал банкны харилцах дансанд үлдэгдэлтэй байсныг авлагаар бүртгэсэн ба авлагыг барагдуулаагүй	154.7	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	43	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын газар, хэлтсийн дарга нарын хүүхдүүдийн сургалтын төлбөрийг тухайн сургуулийн нэхэмжлэхийг үндэслэн байгууллагаас төлсөн	414.0	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	44	Урьдчилж төлсөн тооцоо, өглөгийн үлдэгдлийг тус тус тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй	5,245.5	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	45	Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 4,046.7 сая төгрөгийн 165 тушаалыг шилэн дансанд мэдээлээгүй, хуулийн дагуу байршуулбал зохих мэдээллээс 31 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	4,046.7	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	46	Байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь ерөнхий захирлын “Эрх шилжүүлэх тухай” тушаалд дурдагдаагүй эрхийг эдлэн 2019 оны ДҮ-63-12-549 тоот албан бичгээр “Сэлэнгэ” амралт, аялал жуулчлалын цогцолборын Голомт, ХХБ банк дахь харилцах дансдын 1, 2 дугаар гарын үсэг эзэмшигчийг тодорхойлж, дансны гарын үсгийн баталгаа гаргуулах эрх олгосноор гүйлгээ хийгдсэн.	1,568.1	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	47	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хараат компани “Эрдмин” ХХК-ийн зарласан ногдол ашгийн тооцооллыг үнэн зөв гэж үзэх боломжгүй байна. Хөрөнгө оруулсан компаниудын санхүүгийн тайланг аудитад хамруулж	-	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд

		байх, аудит хийсэн тайланг авч хэвших" гэсэн өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй.				
	48	"Ажилчдын ажлын цагийн бүртгэл, халуун хоолны тооцоог программд гараар оруулдаг, цалин хөлс, хоолны төлбөр тооцоонд бүртгэлээр тавих хяналт сул байгаа нь эрсдэл үүсгэх тул бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах" гэсэн өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй	-	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	49	Овоолгын өртгийг тооцож, санхүүгийн тайланд тусгах гэсэн өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй.	-	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
	50	Дээд газрын шийдвэргүйгээр тайлант онд "Серж Классик Меценат Сан"-д хүндэтгэлийн тоглолтод зориулан хандивласан байна.	13.4	Албан шаардлага	Ерөнхий захирал, Нягтлан бодогч	Х.Бадамсүрэн, Ц.Мөнхболд
"Эрдэнэс таван толгой" ХК	51	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 38 мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй.	306.0	Албан шаардлага	Дотоод хяналт, эрс-дэлийн удирдлагын газрын захирал	Х.Нурлат
	52	Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр бүхий 7 гишүүнд Засгийн газраас тогтоосон хувь хэмжээнээс нийт 52.7 сая төгрөгөөр илүү цалин олгосон.	52.7	Албан шаардлага	ТУЗ-ийн дарга	Б.Бат-эрдэнэ
"Таван толгой төмөр зам"	53	ТУЗ-ийн урамшууллаас НДШ суутгаагүй	7.1	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Удаанжаргал Б.Цэрэнлхам
	54	Нийт ажиллагсад олгосон урамшууллаас НДШ суутгаагүй	101.0	Албан шаардлага		
	55	Ерөнхий инженерийн нэрэмжит нэмэгдэл цалин урамшуулалд НДШ суутгаагүй	28.8	Албан шаардлага		
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны аппарат	56	Албан ажлын суудлын машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад унааны мөнгө 2.0 сая төгрөгийг илүү олгосон.	2.0	Төлбөрийн акт	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
	57	Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн нийт 312.4 сая төгрөгийг илүү олгосон, "Ковид-19" цар тахлаас урьдчилан	394.5	Албан шаардлага	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг

		сэргийлэх зорилгоор шаардлагатай худалдан авалт хийх санхүүжилт олгосныг 4.9 сая төгрөгийг үрэлгэн, 77.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.				
	58	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх зөрчлийг давтан гаргаж, тайлант онд 73.8 сая төгрөгийн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, мөн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч баримт материалыг эцэслэж дуусаагүй байна.	73.8	Албан шаардлага	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
Ашигт малтмал, газрын тосны газар	59	Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг холбогдох байгууллагаар төсөвт суулгаж батлуулаагүй зарцуулсан.	971.9	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	60	Төлөөлөгчийг дэмжих орлогоос ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2 удаа тушаал гарган, үр дүнгийн урамшуулал хэлбэрээр цалингийн бүрэлдэхүүнд оруулж бүх ажилчдад шалгуур үзүүлэлтгүй мөнгөн урамшуулал олгосон	207.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	61	Гэрээт ажилчдад нийгмийн асуудлыг дэмжих гэсэн тушаал гарган үр дүнгийн урамшуулал олгосон	21.2	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	62	МУЗГ-аас цар тахлын үед тэвчиж болох зарим зардлыг бууруулах, тус зардлаас орлого бүрдүүлэх чиглэл өгч 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 168 тоот тогтоол гаргасныг хэрэгжүүлж ажиллаагүй спорт заалны түрээсийн төлбөр шилжүүлсэн.	2.2	Төлбөрийн акт	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	63	Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн.	50.7	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	64	Шатахууны зардалд 10.2 сая төгрөг урьдчилж гарсан зардлаар шилжүүлж хэрэгцээ шаардлагаас илүү шатахуун худалдан авсан.	10.2	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Х.Хэрлэн Х.Чулуунцэцэг
	65	Өглөгийн 0.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	0.7	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	О.Чулуун Ц.Баатарсүрэн

Үндэсний геологийн алба	66	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 46 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5.5 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.	5.5	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	О.Чулуун Ц.Баатарсүрэн
УУХҮЯ-ын геологийн байгууллага	67	2011-2014 онуудад хийгдсэн судалгааны ажлын 46 хувь буюу 6,457.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн гэрээг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнүүлээгүй байна.	6,457.0	Албан шаардлага	ТНБД Ерөнхий нягтлан бодогч	Г.Нандинжаргал М.Нямсүрэн
	68	2012-2014 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын барьцаа төлбөрийн үлдэгдлээс 41.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Барьцаа дансны өглөгийн дансны зарцуулалт тодорхойгүй байна	41.3	Төлбөрийн акт тогтоох	ТНБД Ерөнхий нягтлан бодогч	Г.Нандинжаргал М.Нямсүрэн
	69	Геологийн судалгааны 2016-2019 онуудад хийгдсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнэж, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг хүлээн авч, урьдчилгаа төлбөрийн дансны үлдэгдлийг бууруулж тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй 10,025.5 сая төгрөгийн хуримтлагдсан урьдчилгаа төлбөрийн үлдэгдэлтэй байна. Мөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	10,025.5	Албан шаардлага	ТНБД Ерөнхий нягтлан бодогч	Г.Нандинжаргал М.Нямсүрэн
	69	Акт, албан шаардлагын нийт дүн	89,286.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 592/AO/60057

Улаанбаатар хот

С.дг. 2021/25/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, мөн геологийн судалгааны 2016-2019 онуудад хийгдсэн зарим гэрээт ажлын биелэлтийг тухай бүр дүгнээгүй, судалгааны ажлын тайлан болон холбогдох материалыг хүлээн авч, урьдчилгаа төлбөрийн дансны үлдэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй 10,025,478.4 мянган төгрөгийн хуримтлагдсан урьдчилгаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

[Signature]

[Signature]

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

М.ЛХАГВАСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 593/20160057
СДГ - 2021/25/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологийн байгууллагын санхүүжилтээр 2011-2014 онуудад хийгдсэн судалгааны ажлын 46 хувь буюу 6,456,989.6 мянган төгрөгийн ажил гүйцэтгэсэн гэрээг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2015 оны 108 тоот тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 3.22-д "төсөл гүйцэтгэгч нь ...геологи судалгааны ажлын тайланг хугацаандаа ЭБМЗ, Геологийн мэдээллийн төв архивд хүлээлгэн өгөөгүй тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсоох, төлбөр торгуулийг барьцаа хөрөнгөнөөс барагдуулна", журмын 5.1-д "Төсөл гүйцэтгэгч нь геологи судалгааны ажлын үр дүнгийн тайланд шүүмж хийлгэн, ... ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх, Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэл буюу ажил гүйцэтгэсэн гэрээг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж байх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

М.ЛХАГВАСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 04 дугаар сарын 26

№ 114/А0160057

Улаанбаатар хот

С АТ- 20 21/25/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологийн байгууллагын санхүүжилтээр 2012-2014 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын барьцаа төлбөрийн үлдэгдлээс 41,292.8 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Барьцаа дансны өглөгийн дансны зарцуулалт тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Геологийн байгууллагын санхүүжилтээр 2012-2014 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын барьцаа төлбөрийн үлдэгдэл 41,292.8 /дөчин нэгэн сая, хоёр зуун ерэн хоёр мянга, найман зуу/ мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

М.ЛХАГВАСҮРЭН

001090190